



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 4/576

Номгон

Гамшгаас хамгаалах дадлага, сургууль,
бэлэн байдлын үзлэг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 17/59 тогтоолын хавсралтаар батлагдсан 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний 112 дугаарт заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Баянхонгор аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний 112 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор сум орон нутгийн гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, иргэд олон нийтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх гамшгаас хамгаалах "Иж бүрэн сургууль"-ийг Баянлиг, Хүрээмарал, "Команд штаб"-ын сургуулийг Богд, Жаргалант сумдад, аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах "Бэлэн байдлын үзлэг"-ийг Баян-Өндөр, Галуут сумдад тус тус зохион байгуулсугай.

2.Гамшгаас хамгаалах дадлага, сургууль, аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, хуваарийг хоёрдугаар, шаардагдах зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Гамшгаас хамгаалах дадлага, сургууль аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт шаардагдах 5,000,000 (Таван сая) төгрөгийг аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар хурандаа (Ж.Алтангэрэл)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

624211289

Аймгийн Засаг даргын оны ...
дүгээр сарын-ны өдрийн ... дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт.

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч	1.	Б.Мягмарсүрэн	Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга, дэд хурандаа;
Гишүүд	2.	Ж.Батзолбоо	Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад;
	3.	Б.Буяндэлгэр	Ангиллын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч;
	4.	Г.Энхбаяр	Онцгой байдлын газрын Эмч-сэтгэл зүйч, дэслэгч;
	5.	Л.Ганбаяр	Мал эмнэлгийн газрын Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч;
	6.	А.Гончигсумлаа	Зоонозын өвчин судлалын төвийн Нян судлагч эмч;
	7.	Э.Лувсанпэрэнлэй	Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах бүлгийн Аврагч, жолооч- холбоочин, ахлах ахлагч;
	8.	Б.Мөнхнасан	Гал түймэр унтраах, аврах 16-р ангийн Аврагч, гал сөнөөгч, ахлах ахлагч;
	9.	Б.Ундармаа	Улаанзагалмай хорооны Арга зүйч;
Нарийн бичиг	10.	Г.Баярсайхан	Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлтгэл бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч.

-----oO-----

Аймгийн Засаг даргын оны
дугаар сарын-ны өдрийндугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГУУЛЬ ДАДЛАГА,
БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХУВААРЬ

Д/д	Сургууль дадлага, бэлэн байдлын үзлэг зохион байгуулагдах сум	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
1	2	3	4	5
Гамшгаас хамгаалах “Иж бүрэн сургууль”				
1.	Баянлиг	2024.10.21- 2024.10.31	Онцгой байдлын газар	Мал эмнэлгийн газар, Зоонозын өвчин судлалын төв
2.	Хүрээмарал			
Гамшгаас хамгаалах “Команд штабын сургууль”				
3.	Богд	2024.10.21- 2024.10.31	Онцгой байдлын газар	Мал эмнэлгийн газар, Зоонозын өвчин судлалын төв
4.	Жаргалант			
Аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах “Бэлэн байдлын үзлэг”				
5.	Баян-Өндөр	2024.10.21- 2024.10.31	Онцгой байдлын газар	Мал эмнэлгийн газар, Зоонозын өвчин судлалын төв
6.	Галуут			

-----oOo-----

Аймгийн Засаг даргын оны
дүгээр сарын-ны өдрийн дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГУУЛЬ ДАДЛАГАД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

А.ШАТАХУУН

Д/д	Сумын нэр	Зохион байгуулах хугацаа	Автомашин	Нийт явах зам (км)	Шатахууны норм (дизель)	Зарцуулах шатахуун (литр)	Шатахууны үнэ /төгрөг/	Нийт
1	2	3	4	5	6	7	8	9
1.	Баянлиг	2024.10.10- 2024.10.18	Ланд Крузер-78	150	20	40	3390	135,600
2.	Хүрээмарал			450	20	100	3390	339,000
3.	Богд			130	20	40	3390	135,600
4.	Жаргалант			140	20	40	3390	135,600
5.	Баян-Өндөр			200	20	40	3390	135,600
6.	Галуут			90	20	20	3390	67,800
7.	Нийт			1160	20	280	3390	949,200

Б. СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН МАТЕРИАЛ

Д/д	Нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд
1	2	3	4	5	6
1.	Сумдын газрын зураг(1:500,000масштабтай)	Ширхэг	6	110,000	660,000
2.	Гал унтраагуур	Ширхэг	30	85,000	2,550,000
3.	Анонас (сургууль, дадлагын)	Ширхэг	3	90.000	270.000
4.	Принтерийн хор(өнгөт)	Ширхэг	12	8500	102,000

1	2	3	4	5	6	7
5.	Урьдчилан сэргийлэх ажлын зардал	Принтерийн хор(хар)	Ширхэг	2	85,000	170,000
6.		Бичгийн цаас	Боодол	6	25,000	150,000
7.		Фото цаас	Боодол	8	18,600	148,800
8.	Нийт					4,050,800

В. НЭГДСЭН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Нэр	Нийт зардал
1	2	3
1.	Шатахуун	949,200
2.	Сургалтын хэрэглэгдэхүүн, урьдчилан сэргийлэх ажлын материал	4,050,800
3.	Нийт дүн	5,000,000

-----oOo-----